

# ХАДЛАНГИЙН ТАЛБАЙ БОРДООЖУУЛАХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАЙЛАН



## “Хадлангийн талбайг бордоожуулах”

Ховд аймгийн  
Зэрэг сумын  
Баруун хөвөө  
БАХ

ХЭРЭГЖҮҮЛСЭН ХУГАЦАА: 2020 ОНЫ 06-09 САР

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨГ:

### Төсөл хэрэгжсэн газар

Ховд аймаг Зэрэг сум

### Төслийн зорилго

Хадлангийн талбайг бордоожуулснаар ургацын хэмжээ нэмэгдэнэ, 4 багийн малчид хадлангаа хүрэлцээтэй хэмжээнд авч, өвөл, хаврын улирлыг хохирол багатай давах боломж бүрдэнэ. Цөлжилт саарч бэлчээр сэргэх таатай нөхцөл боломж бүрдэнэ.

### Төслийн зорилтууд

Хадлангийн талбайн суваг шуудууг татаж бордоог цацах, малыг 6-р сард багтааж гаргах, ургацыг нэмэгдүүлж, малчдад хүртээмжтэй болгох.

### Үйл ажиллагаа

Хадлангийн талбайн шуудууг малтан сэргээх, бордоог Ховд аймгаас татан авч ирж усанд жигд хэмжээгээр урсгах, талбайг малаас чөлөөлөх. Энэ хадлангийн талбайгаас манай сумын 4 багийн 300

гаруй малчин өрх хадлангаа авч малын тэжээлд зориулагддаг юм. Эдгээр ажлыг зохион байгуулахад 100 гаруй малчид биечлэн оролцлоо.

### Төслийн хөрөнгө оруулалт

Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Санхүүж илт, төгрөг
Төслөөс	600000
ОНХС	-
СБАХ	-
малчид	100000
<b>Нийт</b>	<b>700000</b>



Зураг



# ХАДЛАНГИЙН ТАЛБАЙ БОРДООЖУУЛАХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАЙЛАН

## Хөрөнгө оруулалтын зарцуулалт

Төслийн санхүүжилтийг юунд зарцуулсан талаар доорх хүснэгтэнд мэдээлэл оруулна

№	Хөрөнгө оруулалтын зарцуулалт	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Бордоо худалдан авах	кг	1000	500	500000
2	Тээврийн зардал				100000
3	Шуудуу татах, ус боох бусад зардал				100000
	<b>Нийт</b>				<b>700000</b>

## Борлуулалт, үйлчилгээний орлого

Төсөл хэрэгжсэнээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээ, тэдгээрээс олсон орлогын талаар энэ хүснэгтэнд мэдээлэл оруулна.

№	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	Хэмжих нэгж	Тоо	Нэгжийн үнэ	Нийт, төг
1	Өвсний хэмжээ	тн	2000	60000	120000000
	<b>Нийт</b>				<b>120,000,000</b>

## ТӨСЛИЙН ҮР ДҮН

2019 онд хадлангийн талбайд бордоо хэрэглээгүй үед авсан өвсний хэмжээ 1800 тн байсан бөгөөд 1 тн 80000 төгрөг байсан юм.

Төсөл хэрэгжүүлсний үр дүнд хурааж авсан хадлан 200 тонноор нэмэгдэж 1 тонн өвсний өртөг нь 20000 төгрөгөөр буурч, 4 сая төгрөг урд оныхоос хэмнэсэн тооцоо гарч байна.



# ХАДЛАНГИЙН ТАЛБАЙ БОРДООЖУУЛАХ ТӨСЛИЙН ТОВЧ ТАЙЛАН

## ТӨСЛИЙН ҮР ШИМ ХҮРТЭГЧ

Хадлан авдаг 300 малчин өрх 2000 тонн хадланг өөрсдийн хүчээр хийж өвөл, хаврын улиралд мал тэжээх зорилгоор ашиглаж байна.

## ТӨСЛИЙН ЗОРИУЛАЛТ

Төслийг зориулалтын дагуу хийж зарцуулалтанд нь ямар нэгэн өөрчлөлт ороогүй болно. Цаашид 2021 онд хадлангийн талбайд хийх бордоог 4-5 тонныг бэлтгэж авах, хадлангийн талбайг 6-р сарын 15-ны дотор малаас чөлөөлөх арга хэмжээг Бураа, Бургасан багийн иргэдтэй бүрэн тохиролцсон байх.

**АЖЛЫН ТАЙЛАН ГАРГАСАН**  
**СУМЫН БАХ-НЫ ТЭРГҮҮН**

**Б .ОДХҮҮ**